

БИДНИЙ УРИА

Таны амар тайван амьдралын баталгаа

БИДНИЙ ЗОРИЛТ

Даатгуулагчийн эрэлт хэрэгцээг бүрэн хангасан
санаснаас нь хол давсан үйлчилгээг үзүүлнэ

ЭРХЭМ ЗОРИЛГО

Харилцагч үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээ шаардлагыг хангасан бүтээгдэхүүнээр
даатгалын мэргэжлийн үйлчилгээг үзүүлэн нийгмийн өмнө хүлээсэн
үүргээ биелүүлж
монгол улсын даатгалын зах зээлд тэргүүлэгч компани болоход оршино

ТАНИЛЦУУЛГА

“Номин Даатгал” ХХК нь 2001 онд байгуулагдсан цагаасаа хойш богино хугацаанд
даатгалын зах зээл дээр өөрийн байр суурийг бэхжүүлж тэргүүлэгч компаниудын нэг
болж чадсан.

Манай компани төрөл бүрийн төсөл хөтөлбөрүүдэд тогтмолоролцож, гадаадын болон
дотоодын компаниуд, төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдэд даатгалын
үйлчилгээг үзүүлж ирсэн бөгөөд харилцагчидтайгаа удаан хугацааны туршид хамтын
ажиллагааг амжилттай үргэлжлүүлсээр байна.

Бидиргэд, аж ахуйн нэгж байгууллагуудынхэрэгцээ шаардлагыг дээд зэргээр
хангасанбүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх зорилгоор даатгалын уян хатан нөхцөл санал
болгож урт хугацааны бат бэх найдвартай харилцаа тогтоохыг цаг ямагт эрмэлзэн
ажилласаар байна.

Улаанбаатар хотод 4 салбар, 4 төлөөлөгчийн газар, 7 санхүүгийн үйлчилгээний цэг,
орон нутагт 20 салбараар дамжуулан үйл ажиллагаа явуулж байна.

ДАВХАР ДААТГАЛ

Бид даатгуулагчдийн өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэх зорилгоор олон улсын
AAA зэрэглэл бүхий үндэстэн дамнасан томоохон давхар даатгалын компани болон
брокеруудтай хамтран ажилладаг тул хэмжээний хувьд ямарч том эрсдэлийг хүлээн
авах найдвартай баталгаагаар хангагдсан юм. Тухайлбал: Hannover Re, Kiln Asia
Limited, General Insurance Corporation, J.V.Boda Group зэрэг Лондоны Ллойдсын
брокерууд болон андеррайтеруудтай хамтран ажиллаж байна.

МАНАЙ ДАВУУ ТАЛУУД

- Үндэсний хөрөнгө оруулалттай компани
- Даатгуулагчдийн тоо харьцангуй олон тул эрсдэлийг хангалттай тараан байршуулсан
- Давхар даатгалын өндөр хамгаалалт
- Харилцагчийн хэрэгцээнд тулгуурлан боловсруулсан бүтээгдэхүүн
- Харилцагчдыг халамжлах үйлчилгээ болон борлуулалтын дараах үйлчилгээ
- Даатгалынчиглэлээр сургалтзөвлөгөө өгөхүйлчилгээ
- Эрсдэлийн шинжилгээ хийх, зөвлөгөө өгөх үйлчилгээ
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны бүх төрлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ
- Даатгалын хураамж төлөх хөнгөлттэй нөхцөлүүд
- Ослын дуудлагын үйлчилгээ /24 цагаар/

ГАДААДАД ЗОРЧИГЧИЙН ДААТГАЛ

Даатгуулагч гадаадад зорчих хугацаанд даатгалын эрсдэлийн улмаас хохирол учирсан тохиолдолд холбогдох зардлыг даатгалын гэрээний нөхцлийн дагуу нөхөн төлнө.

Даатгалын зүйл:

Эрүүл мэнд, амь нас /0,3-80 настай/

Даатгалын эрсдэл нь:

- Гэнэтийн осол- гадны нөлөөтэй, гэнэтийн, санамсаргүй өвчин эмгэгтэй хамааралгүй тохиолдол даатгуулагчийн бие мах бодид гэмтэл учруулахыг
- Гэнэтийн өвчлөл- аяллаас өмнө оношлогдож эсвэл эмчлэгдэж байгаагүй, гадаадад зорчиж байх хугацаанд яаралтай эмчилгээ хийлгэх шаардлагатай аливаа өвчнийг

ҮНДСЭН ХАМГААЛАЛТЫН ХҮСНЭГТ

/ам.доллараар/

Хамгаалалтын төрөл	Нас баралт	Эмчилгээний зардал:гэнэтийн өвчлөл	Эмчилгээний зардал:гэнэтийн осол	Эмнэлгийн нүүлгэн шилжүүлэлт	Шарил буцаан тээвэрлэх	
A	Нөхөн төлбөрийн дээд хэмжээ	20,000	20,000	20,000	20,000	20,000
	Даатгуулагчийн хариуцах хэсэг		50	100		
B	Нөхөн төлбөрийн дээд хэмжээ	50,000	50,000	25,000	40,000	40,000
	Даатгуулагчийн хариуцах хэсэг		50	150		
C	Нөхөн төлбөрийн дээд хэмжээ	100,000	100,000	25,000	50,000	50,000
	Даатгуулагчийн хариуцах хэсэг		50	200		
D	Нөхөн төлбөрийн дээд хэмжээ	200,000	200,000	20,000	50,000	50,000
	Даатгуулагчийн хариуцах хэсэг		50	100		

Нэмэлт эрсдэл нь:

НЭМЭЛТ ХАМГААЛАЛТЫН ХҮСНЭГТ

/ам.доллараар/

1	Яаралтай шүдний эмчилгээ	Нөхөн төлбөрийн дээд хэмжээ	1,000
		Даатгуулагчийн хариуцах хэсэг	50
2	Баримт бичиг алга болох	Нөхөн төлбөрийн дээд хэмжээ	1,500
3	Хуулийн хариуцлага	Нөхөн төлбөрийн дээд хэмжээ	2,000

4	Нислэгт шалгуулсан ачаа тээш саатах	Нөхөн төлбөрийн дээд хэмжээ	150
5	Ачаа тээш хулгайд алдах	Нөхөн төлбөрийн дээд хэмжээ /бичиг баримт бүрэн үед/	300
		Нөхөн төлбөрийн дээд хэмжээ /Тодорхой улс оронд зөвхөн цагдаагийн тодорхойлолтонд үндэслэсэн үед/	150
		Ачаа тээшин доторхи эд зүйлс тур бүрт олгох нөхөн төлбөрийн дээд хэмжээ	50
6	Нислэгт шалгуулсан ачаа тээш алга болох, эвдэрч гэмтэх	Нөхөн төлбөрийн дээд хэмжээ /бичиг баримт бүрэн үед/	300
		Нөхөн төлбөрийн дээд хэмжээ /тээвэрлэгч авиа компаний тодорхойлолтонд үндэслэх үед/	150
		Ачаа тээшин доторхи эд зүйл тус бүрт олгох нөхөн төлбөрийн дээд хэмжээ	50
		Ачаа тээш алга болсон үед байрлалыг тогтооход туслах үйлчилгээ үзүүлэх	
7	Нислэг сааталт	Нөхөн төлбөрийн дээд хэмжээ	180

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД:

1. Урьд өмнө мэдэгдэж байсан өвчин, ужиг өвчин, мэдрэлийн өвчин, арьс өнгөний өвчин, Дархлалын олдмол хомсдол болон хүний дархлал хомсдлын вируст өртсөн, төрөлхийн өвчин эсвэл согог, төрөлхийн эрэмдэг байдал, гажуудал эсвэл хромосомын хэвийн бус байдлын эмчилгээ;
2. Одоо байгаа өвчин цаашид хүндрэхийг гадаадад зорчихоос өмнө даатгуулагч урьдчилан мэдэж байсан.
3. Жирэмслэлт, төрөлт, зулбалт, аборт, эмэгтэйчүүдийн үргүйдэл, жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх, үргүй болгох
4. Эмийн харшил, бусад эмнэлэгийн эмчилгээнээс үүдэх хохирол
5. Архи, мансууруулах бодис, согтууруулах ундаа эсвэл тайвшруулах үйлчилгээтэй эм, нойрсуулагч эсвэл бусад мансууруулагч бодис хэрэглэсний улмаас ухаан алдах эсвэл сэтгэцийн өвчинөөс үүдэлтэй аливаа өвчин
6. Даатгуулагчийн санаатай үйлдэл
7. Өөрийгөө гэмтээх, амиа хорлох, гэмт хэрэг үйлдэх, баривчилгааг эсэргүүцэх
8. Даатгуулагчийн санаатай үйлдэл эсвэл бусдыг өдөөн хатгах үйлдэл нь даатгуулагчийг амь насаа алдах, гэмтэж бэртэхэд хүргэсэн тохиолдолд
9. Гоо сайхны мэс засал
10. Эмчийн зөвлөмжгүйгээр эм тариа хэрэглэх

11. Цөмийн эрсдэл
12. Терроризм
13. Мотоциклийн уралдаан, ан агнуур, усан, морь унах, ууланд авирах, бокс, бүх төрлийн барилдаан, бүх төрлийн тулааны урлаг, шүүхрээр буух, агаарын бөмбөлөгөөр аялах, чөлөөт уналт, бүх төрлийн цас мөсний спорт зрэг бүх төрлийн өндөр аюултайд тооцогдох спортоор хичээллэх, тэмцээн уралдаанд оролцох
14. Эмчийн зөвлөсний эсрэг гадаадад зорчих
15. Гадаадад зорчих шалтгаан нь эмчилгээ хийлгэх
16. Гадаадад зорчихоос өмнө даатгуулагч нь эмчийн шаардсан эмчилгээ эсвэл аяллын үеэр бусад эмчилгээг хийлгэх ёстойг мэдэж байсан
17. Даатгуулагч нь байнгын оршин суух эрхтэй эсвэл иргэний харъяалалтай улсад зорчих
18. Дайн, цэргийн үйл ажиллагаа, бослого, үймээн
19. Согтууруулах, мансууруулах бодисны нөлөөн доор
20. Согтуугаар машин жолоодох, жолооны үнэмлэхгүй жолоо барих, улсын бүртгэлгүй тээврийн хэрэгсэл жолоодох
21. Арми, усан, агаарын хүчинд алба хаах, цэргийн ажиллагаанд оролцох
22. Аяллын хугацаанд шүүх, цагдаагийн байгууллагаас саатуулагдсан эсвэл шоронд хорих ял авсан
23. Терроризм, хууль бус шашны бүлэглэлийн үйл ажиллагаанд оролцсон
24. Зорчигчийн бус хувиар агаарын хөлөгт суух
25. Даатгалын хамгаалалт үйлчлэхгүй улс оронд зорчих
26. Даатгалын хамгаалалт авах хүсэлт гаргах үедээ гадаадад байсан
27. Гэнэтийн ослоос үүдэлтэй биш шүдний эмчилгээ эсвэл мэс заслаас шалтгаалсан аливаа зардал, бүх шалтгаанаас шүд сэргээн засах эсвэл шүдний гоо сайхны эмчилгээний төлбөр
28. Гэнэтийн ослоос улбаагүй нүдний хараа зүгшрүүлэх аливаа эмчилгээний зардал, нүдний хараа зүгшрүүлэх зорилгоор хараа зүйн шалгалтын төлбөр
29. Зүрхний электрон төхөөрөмж, хиймэл үе, нүдний харааны туслах төхөөрөмж худалдан авах эсвэл засахад учирсан зардал
30. Ерөнхий эрүүл мэндийн үзлэг, урьдчилан сэргийлэх эмчилгээ, зүүний эмчилгээ, вакцинжуулалт, массаж, шавар эмчилгээ
31. Гоо сайхны мэс засал, пластик мэс засал эсвэл урьдчилан сэргийлэх мэс засал зэрэг яаралтай эмчилгээ шаардахгүй мэс заслын зардал
32. Сувилгааны зардал
33. Психоанализ, психо эмчилгээ болон ховс

Бидэнтэй холбоо барих:

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 6 хороо

Нэгдсэн үндэстний гудамж Германы элчин сайдын яамны урд талд

Салбарын эрхлэгч **Э.Халиунаа**

Утас, 311508, 89887880 e.mail-khaliunaa.e@nomin.net

Даатгал мэргэжилтэн **А.Ариунзаяа**

Утас: 311508, 89887881 e.mail-ariunzaya.a@nomin.net

Facebook page: [Номин Даатгал Герман Элчин Салбар](#)

Нөхөн төлбөрийн алба:

Утас: 1800-2888, 89887701

Факс: 976-75779999 E.mail-insurance@nomin.net